



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 12 сарын 18 өдөр

Дугаар А/600

Улаанбаатар хот

**Сүхбаатар дүүргийн 25 дугаар цэцэрлэгийн
барилга, байгууламж, нийтийн эзэмшлийн
хөрөнгө данснаас хасах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 193 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/1307 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын Улсын байцаагчийн “барилгын ашиглалтыг зогсоох тухай” 2015 оны 02-07-112/330 дугаар актын дагуу тус цэцэрлэгийн балансад бүртгэлтэй хавсралтад заасан нийт 836,783,543.04 /найман зуун гучин зургаан сая долоон зуун наян гурван мянга таван зуун дөчин гурван төгрөг, дөрвөн мөнгө/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий барилга байгууламж, нийтийн эзэмшлийн эд хөрөнгийг акталж, нийслэлийн өмчийн бүртгэлээс хасахыг Сүхбаатар дүүргийн 25 дугаар цэцэрлэг /С.Батцэцэг/-т зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй хөрөнгийг хоёрдогч түүхий эдийн зориулалтаар худалдан борлуулахаар үнэлсэн 4,996,000 /дөрвөн сая есөн зуун ерэн зургаан мянган/ төгрөгөөр худалдан борлуулж, орлогыг Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын нийслэлийн Төрийн сангийн 100200051024 тоот дансанд төвлөрүүлэх, акт болон бусад баримт бичгийн бүрдэлд хяналт тавьж ажиллахыг Урт цагаан үйлчилгээ, аж ахуйн төв /П.Батжаргал/, өмчийн нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний өөрчлөлт хийж ажиллахыг Сүхбаатар дүүргийн 25 дугаар цэцэрлэг /С.Батцэцэг/-т тус тус даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга Д.Рэнцэнбямбад үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ

Ш.ҮНЭНБАТ



Нийслэлийн өмчийн ашиглалт, удирдлагын газрын даргын 2019 оны 12 дугаар сарын 18 өдрийн 0/6 дугаар тушаалын хавсралт

АКТАЛЖ, НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛЭЭС ХАСАХ
 БАРИЛГА, БАЙГУУЛАМЖ, НИЙТИЙН ЭД ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

/төгрөгөөр/

№	Барилга байгууламжийн нэр	Ашигласан жил	Хэмжих	Тоо хэмжээ	Бүртгэлийн үнэ /2019.09.30-ны байдлаар/	Хуримтлагдсан элэгдэл /2019.09.30-ны байдлаар/	Үлдэгдэл өртөг /2019.09.30-ны байдлаар/	Акталж, данснаас хасах үндэслэл
1	Цэцэрлэгийн барилга	63	ш	1	782,631,822.30	782,631,822.30	-	Нийслэлийн Мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн 2015 оны 02-07-112/330 дугаар акт
2	Бохирын шугам	63	у/м	30	1,860,000.00	1,860,000.00	-	
3	Дулааны шугам	63	у/м	32	19,088,980.70	19,088,980.70	-	
4	Цэвэр усны шугам	63	у/м	16	1,088,000.00	1,088,000.00	-	
5	Цахилгааны шугам	63	у/м	60	1,620,000.00	1,620,000.00	-	
Барилга, байгууламжийн дүн					806,288,803.00	806,288,803.00	-	
6	Төмөр хашаа	63	ш	1	1,794,500.00	1,794,500.00	-	
7	Эко хайс	4	м	160	6,320,000.00	2,738,666.84	3,581,333.16	
8	Зүлэгжүүлсэн талбай	24	м2	68	312,800.00	312,800.00	-	
9	Зүлэгжүүлсэн талбай	4	м2	401.4	8,395,281.00	3,637,955.36	4,757,325.64	
10	Шороон талбай	24	м2	800	1,299,200.00	1,299,200.00	-	
11	Нийтийн зориулалттай талбай	24	м2	197	591,000.00	591,000.00	-	

12	Хүүхдийн тоглоомын талбайн резинэн хавтан	4	м2	120	9,900,960.00	4,290,416.00	5,610,544.00
13	Явган хүний зам	4	м2	8	331,199.04	143,519.48	187,679.56
14	Явган замын хашлага /хайс/	4	м	110	1,485,000.00	643,500.00	841,500.00
15	Шилмүүст мод	24	ш	8	50,400.00	50,400.00	-
16	Навчит мод	24	ш	10	14,400.00	14,400.00	-
Нийтийн эзэмшлийн дүн					30,494,740.04	15,516,357.68	14,978,382.36
Нийт дүн					836,783,543.04	821,805,160.68	14,978,382.36